**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Заг сумын ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: БНА-2025/129/НА- СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2025 оны 02 дугаар сарын 24-ний өдөр | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын<br>Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат<br>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Аудитын менежер М.Алтантуяа<br>Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Аудитор Д.Цэдэвцэвээн<br>Утас: 89204984 Цахим хаяг: Tsedevtseveend@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **6,204,200.00** | **6,085,200.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 6,204,200.00 | 6,085,200.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 3,748,900.00 | 3,748,900.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 3,748,900.00 | 3,748,900.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 2,455,300.00 | 2,336,300.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 585,800.00 | 466,800.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 99,000.00 | 99,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,770,500.00 | 1,770,500.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **26,933,596.61** | **28,078,807.10** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 26,933,596.61 | 28,078,807.10 |
| **392** | **Биет хөрөнгө** | 26,933,596.61 | 28,078,807.10 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 18,500,000.00 | 18,500,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -1,156,249.98 | -2,312,499.96 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 14,903,750.00 | 18,280,750.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -7,898,485.13 | -8,989,649.62 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 6,227,741.00 | 6,445,241.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -4,243,159.28 | -4,445,034.32 |
| 39217 | Ном | 600,000.00 | 600,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 100,000.00 | 100,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -100,000.00 | -100,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **33,137,796.61** | **34,164,007.10** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **33,137,796.61** | **34,164,007.10** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 33,137,796.61 | 34,164,007.10 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 4,682,100.00 | 4,682,100.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 4,682,100.00 | 4,682,100.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 27,920,184.15 | 28,946,394.64 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 4,623,014.34 | 27,920,184.15 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 23,297,169.81 | 1,026,210.49 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 535,512.46 | 535,512.46 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **33,137,796.61** | **34,164,007.10** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **168,943,300.00** | **192,078,026.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **0** | **3,594,500.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **0** | **3,594,500.00** |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 0 | 3,594,500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **168,943,300.00** | **188,483,526.50** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **1,300,000.00** | **10,466,326.50** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,300,000.00 | 1,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0 | 9,466,326.50 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **167,643,300.00** | **178,017,200.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 167,643,300.00 | 178,017,200.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **145,646,130.19** | **191,051,816.01** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **145,646,130.19** | **191,051,816.01** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **125,474,670.79** | **168,176,953.17** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **75,855,301.60** | **113,970,099.69** |
| 210101 | Үндсэн цалин | 44,365,321.84 | 59,649,887.37 |
| 210102 | Нэмэгдэл | 31,489,979.76 | 40,966,995.05 |
| 210104 | Урамшуулал | 0 | 13,353,217.27 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **9,478,789.00** | **14,110,233.97** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,449,469.00 | 9,585,671.16 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 758,686.00 | 1,133,813.45 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 610,658.00 | 600,524.73 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 151,552.00 | 510,823.73 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,508,424.00 | 2,279,400.90 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **8,390,900.00** | **7,726,950.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,849,700.00 | 2,919,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,786,800.00 | 4,741,250.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 228,000.00 | 66,700.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 374,000.00 | 0 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,152,400.00 | 0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **0** | **634,880.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0 | 634,880.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,987,000.00** | **4,000,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,987,000.00 | 4,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,495,000.00** | **20,909,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,495,000.00 | 20,909,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **27,267,680.19** | **6,825,789.51** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,963,600.00 | 376,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,300,000.00 | 3,999,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 3,004,080.19 | 2,449,289.51 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **20,171,459.40** | **22,874,862.84** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **2,415,000.00** | **11,661,326.50** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,415,000.00 | 11,661,326.50 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **17,756,459.40** | **11,213,536.34** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 17,756,459.40 | 11,175,136.34 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 0 | 38,400.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **23,297,169.81** | **1,026,210.49** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **23,297,169.81** | **1,026,210.49** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **168,943,300.00** | **188,483,526.50** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **168,943,300.00** | **188,483,526.50** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,300,000.00 | 10,466,326.50 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,300,000.00 | 1,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 9,466,326.50 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 167,643,300.00 | 178,017,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 167,643,300.00 | 178,017,200.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **145,165,550.00** | **188,483,526.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **145,165,550.00** | **188,483,526.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **124,994,090.60** | **165,608,663.66** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 75,855,301.60 | 113,970,099.69 |
| 210101 | Үндсэн цалин | 44,365,321.84 | 59,649,887.37 |
| 210102 | Нэмэгдэл | 31,489,979.76 | 40,966,995.05 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 13,353,217.27 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 9,478,789.00 | 14,110,233.97 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,449,469.00 | 9,585,671.16 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 758,686.00 | 1,133,813.45 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 610,658.00 | 600,524.73 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 151,552.00 | 510,823.73 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,508,424.00 | 2,279,400.90 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,360,500.00 | 7,607,950.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,345,700.00 | 2,800,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,786,800.00 | 4,741,250.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 228,000.00 | 66,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 634,880.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 634,880.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,987,000.00 | 4,000,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,987,000.00 | 4,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,300,000.00 | 20,324,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,300,000.00 | 20,249,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 75,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 28,012,500.00 | 4,961,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,712,500.00 | 961,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,300,000.00 | 3,999,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **20,171,459.40** | **22,874,862.84** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,415,000.00 | 11,661,326.50 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 9,466,326.50 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,415,000.00 | 2,195,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 17,756,459.40 | 11,213,536.34 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 17,756,459.40 | 11,175,136.34 |
| 213404 | Хөрөнгийн | 00.00 | 38,400.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **23,777,750.00** | **00.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **23,777,750.00** | **00.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **23,777,750.00** | **00.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 23,777,750.00 | 00.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 23,777,750.00 | 00.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-23,777,750.00** | **00.00** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **4,682,100.00** | **535,512.46** | **4,623,014.34** | **9,840,626.80** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **4,682,100.00** | **535,512.46** | **4,623,014.34** | **9,840,626.80** |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | **0** | **0** | **23,297,169.81** | **23,297,169.81** |
| **10** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **4,682,100.00** | **535,512.46** | **27,920,184.15** | **33,137,796.61** |
| **11** | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **4,682,100.00** | **535,512.46** | **27,920,184.15** | **33,137,796.61** |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **4,682,100.00** | **535,512.46** | **27,920,184.15** | **33,137,796.61** |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | 1,026,210.49 | 1,026,210.49 |
| **20** | **2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **4,682,100.00** | **535,512.46** | **28,946,394.64** | **34,164,007.10** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэл зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **178,017,200.00** | **166,842,063.66** | **11,175,136.34** | **93.72** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **178,017,200.00** | **166,842,063.66** | **11,175,136.34** | **93.72** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **174,517,200.00** | **164,647,063.66** | **9,870,136.34** | **94.34** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **120,859,700.00** | **113,970,099.69** | **6,889,600.31** | **94.30** |
| 210101 | Үндсэн цалин | 65,725,700.00 | 59,649,887.37 | **6,075,812.63** | **90.76** |
| 210102 | Нэмэгдэл | 45,628,600.00 | 40,966,995.05 | **4,661,604.95** | **89.78** |
| 210104 | Урамшуулал | 9,505,400.00 | 13,353,217.27 | **-3,847,817.27** | **140.48** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **15,107,500.00** | **14,110,233.97** | **997,266.03** | **93.40** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,273,100.00 | 9,585,671.16 | **687,428.84** | **93.31** |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,208,600.00 | 1,133,813.45 | **74,786.55** | **93.81** |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 604,300.00 | 600,524.73 | **3,775.27** | **99.38** |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 604,300.00 | 510,823.73 | **93,476.27** | **84.53** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,417,200.00 | 2,279,400.90 | **137,799.10** | **94.30** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **8,600,000.00** | **7,607,950.00** | **992,050.00** | **88.46** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,800,000.00 | 2,800,000.00 | **0.00** | **100.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,000,000.00 | 4,741,250.00 | **258,750.00** | **94.83** |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 800,000.00 | 66,700.00 | **733,300.00** | **8.34** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **650,000.00** | **634,880.00** | **15,120.00** | **97.67** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 650,000.00 | 634,880.00 | **15,120.00** | **97.67** |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **4,000,000.00** | **4,000,000.00** | **0.00** | **100.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,000,000.00 | 4,000,000.00 | **0.00** | **100.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,** | **21,300,000.00** | **20,324,000.00** | **976,000.00** | **95.42** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **үйлчилгээний төлбөр, хураамж** | | | | |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 21,000,000.00 | 20,249,000.00 | **751,000.00** | **96.42** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 300,000.00 | 75,000.00 | **225,000.00** | **25.00** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **4,000,000.00** | **3,999,900.00** | **100.00** | **100.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0 | 0 | **0.00** | **0.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,000,000.00 | 3,999,900.00 | **100.00** | **100.00** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,500,000.00** | **2,195,000.00** | **1,305,000.00** | **62.71** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **3,500,000.00** | **2,195,000.00** | **1,305,000.00** | **62.71** |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 0 | 0 | **0.00** | **0.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,500,000.00 | 2,195,000.00 | **1,305,000.00** | **62.71** |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **178,017,200.00** | **166,842,063.66** | **11,175,136.34** | **93.72** |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **178,017,200.00** | **166,842,063.66** | **11,175,136.34** | **93.72** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 178,017,200.00 | 166,842,063.66 | **11,175,136.34** | **93.72** |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 0 | **0** | **0** |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 0 | **0** | **0** |

Аудитаар 122.4 мянган төгрөгийн алдаа илрүүлж аудитын явцад залруулсан.

Нийгмийн даатгалын мэдээг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 109.0 мянган, даатгуулагчаас төлөх 13.3 мянган төгрөг нийт 122.4 мянган төгрөгийн зөрүүтэй мэдээлсэн байсныг завсрын аудитаар илрүүлэн залруулсан

**Гурав. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:**

Аудитаар 14,744.3 мянган төгрөгийн 4 зөрчил илрүүлснээс 14,527.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 217.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн. Үүнд:

**3.1 Албан шаардлага**

**3.1.1** Сумын ИТХ-ын даргын 2024 оны А/10 дугаар захирамжаар ИТХ-ын төлөөлөгч нарт тойрогтоо ажиллах үйл ажиллагааны зардал тус бүр 770.0 мянган төгрөг нийт 14,000.0 мянган төгрөг данс руу нь шилжүүлсэн ба зарцуулалтын тайлан холбогдох анхан шатны баримт байхгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор баталсан "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.8-т "Төлөөлөгчийн зардлыг бэлнээр олгохгүй бөгөөд үнийн нэхэмжлэх болон бусад баримтыг үндэслэн зардлын хязгаарт багтаан холбогдох санхүүжилтийг тухайн байгууллагад шилжүүлнэ", 4.1-т "Төлөөлөгч нь үйл ажиллагааныхаа төсвийн зарцуулалтын тайлан, холбогдох санхүүгийн баримтыг зохих хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бүрдүүлж, тогтоосон журмын дагуу Хурлын ажлын албанд тухай бүр гаргаж өгнө" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*<u>Шийдвэрлэсэн нь:</u>* Зөрчлийг таслан зогсоож, үйл ажиллагааныхаа төсвийн зарцуулалтын тайлан, холбогдох санхүүгийн баримтыг зохих хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бүрдүүлж нотлох баримтыг ирүүлэх албан шаардлага хүргүүлэв.

**3.1.2** ИТХ-ын хуралдааны зардлаас 2024.10.29-ны өдөр 527.3 мянган төгрөгийг Б.Ганцэцэгийн данс руу ХХОАТ суутган шилжүүлсэн ба ямар нэгэн тушаал шийдвэр, холбогдох материал, анхан шатны баримт байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх "Үнэн зөв байх" 13 дугаар зүйлийн 13.5 дахь "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтуудыг зөрчсөн байна

*<u>Шийдвэрлэсэн нь:</u>* Алдаа зөрчлийг таслан зогсоож, үйл ажиллагааныхаа төсвийн зарцуулалтын тайлан, холбогдох санхүүгийн баримтыг зохих хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бүрдүүлж нотлох баримтыг ирүүлэх албан шаардлага хүргүүлэв.

**3.2 Зөвлөмж**

**3.2.1** ИТХ-ын хуралдааны зардлаар авсан үйлчилгээ үзүүлэхэд ашиглан зарцуулах хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа нийт 4,961.5 мянган төгрөгийн холбогдох материал /нэг удаагийн аяга, халбага, кофе, гарын авлага/-ыг бараа материалын тайланд орлого авахгүй шууд зарлагаар гаргасан байна

Энэ нь Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8 дугаар зүйлийн 8.1-т "Үйлдвэрлэлд ашиглах түүхий эд материал, үйлчилгээ үзүүлэхэд ашиглан зарцуулах хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа, худалдан борлуулах, хуваарилах зорилгоор эзэмшиж байгаа, борлуулах буюу хуваарилахын тулд үйлдвэрлэлийн дамжлагад байгаа хөрөнгө бараа материалд хамрагдана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*<u>Шийдвэрлэсэн нь:</u>* Бараа материалыг Сангийн сайдын 2025 оны 03 дугаар тушаалаар баталсан журмын дагуу тайлагнах зөвлөмж хүргүүлэв.

**3.3 Төлбөрийн акт**

**3.3.1** ИТХ-ын нарийн бичгийн даргын 2024 оны А/11 дүгээр тушаалаар иргэн М.Отгонтуяад сумын хэмжээнд ашиглаж байгаа замын тэмдэглэгээ сэргээн засварласан хөлс болох 217.0 мянган төгрөг олгосон ба ажил гүйцэтгэх гэрээ байгуулаагүй, ажлыг дүгнэсэн нотлох баримт байхгүй иргэний гаргасан өргөдлийг үндэслэн олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх "Үнэн зөв байх" 13 дугаар зүйлийн 13.5 дахь "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

*<u>Шийдвэрлэсэн нь:</u>* Цаашид ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, ажлыг дүгнэн санхүүжилтийг олгох, холбогдох анхан шатны баримтыг бүрдүүлж ирүүлэх зөвлөмж хүргүүлэв.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)**

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Нийгмийн даатгалын мэдээг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 109.0 мянган, даатгуулагчаас төлөх 13.3 мянган төгрөг нийт 122.4 | 1 | 122.4 | | | | | 1 | 122.4 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| мянган төгрөгийн зөрүүтэй мэдээлсэн байсныг завсрын аудитаар илрүүлэн залруулсан. | | | | | | | | | | | | |
| Дүн | 1 | 122.4 | | | | | 1 | 122.4 | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцох албан шаардлага | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ИТХ-ын хуралдааны зардлаар авсан үйлчилгээ үзүүлэхэд ашиглан зарцуулах хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа холбогдох материал /нэг удаагийн аяг, халбага, кофе, гарын авлага/-ыг бараа материалын тайланд орлого авахгүй шууд зарлагаар гаргасан байна. | 1 | 4,961.5 | | | | | 1 | 4,961.5 | | |
| Сумын ИТХ-ын даргын 2024 оны А/10 дугаар захирамжаар ИТХ-ын төлөөлөгч нарт тойрогтоо ажиллах үйл ажиллагааны зардал тус бүр 770,000 төгрөгөөс ХХОАТ суутган 700,000 төгрөг нийт 14,000,000 төгрөг данс руу нь шилжүүлсэн ба зарцуулалтын тайлан холбогдох анхан шатны баримт байхгүй байна. | 1 | 14,000.0 | | | 1 | 14,000.0 | | | | |
| ИТХ-ын хуралдааны зардлаас 2024.10.29-ны өдөр 527,300 төгрөг Б.Ганцэцэгийн данс руу ХХОАТ суутган шилжүүлсэн ба ямар нэгэн тушаал шийдвэр, холбогдох материал, анхан шатны баримт байхгүй байна. | 1 | 527.3 | | | 1 | 527.3 | | | | |
| ИТХ-ын нарийн бичгийн даргын 2024 оны А/11 дүгээр тушаалаар иргэн М.Отгонтуяад сумын хэмжээнд ашиглаж байгаа замын тэмдэглэгээ сэргээн засварласан хөлс болох 217,000 төгрөг олгосон ба ажил гүйцэтгэх гэрээ байгуулаагүй, ажлыг дүгнэсэн нотлох баримт байхгүй иргэний гаргасан өргөдлийг үндэслэн олгосон байна. | 1 | 217.0 | 1 | 217.0 | | | | | | |
| | 4 | 19,083.9 | 1 | 217.0 | 2 | 14,527.3 | 1 | 4,961.5 | | |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | Санал дүгнэлтийн хэлбэр |
|---|---|---|---|---|
| | | Аудитад | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | |

| | | | Санал дүгнэлт гаргасан | Тувэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | | | + | | | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | | | + | | | | | |

---oOo---

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 05 өдөр Дугаар 81 Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Заг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын 2024 оны А/11 дүгээр тушаалаар иргэн М.Отгонтуяад сумын хэмжээнд ашиглаж байгаа замын тэмдэглэгээ сэргээн засварласан хөлс болох 217,000 (Хоёр зуун арван долоон мянган) төгрөг олгосон ба ажил гүйцэтгэх гэрээ байгуулаагүй, ажлыг дүгнэсэн нотлох баримт байхгүй иргэний гаргасан өргөдлийг үндэслэн олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” , Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх "Үнэн зөв байх" 13 дугаар зүйлийн 13.5 дахь "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан

5050165

гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Замын тэмдэглэгээ сэргээн засварласан хөлсөнд олгосон 217,000 (Хоёр зуун арван долоон мянган) төгрөгийг төсөв захирагч, нягтлан бодогчоор нөхөн төлүүлж, Төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төлбөрийг төвлөрүүлэх. төвлөрүүлэх[1]

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нотлох баримтыг 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын С.Туяацэцэг, нягтлан бодогч Б.Доржнамжим нарт даалгав[2].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[3]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Д.ЦЭДЭВЦЭВЭЭН

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[3] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 178/ Номгон

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Заг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын ИТХ-ын хуралдааны зардлаас 2024 оны 10 дугаар сарын 29-ны өдөр 527,300 (Таван зуун хорин долоон мянга гурван зуун) төгрөг Б.Ганцэцэгийн данс руу шилжүүлсэн ба ямар нэгэн тушаал шийдвэр, холбогдох материал, анхан шатны баримт байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх "Үнэн зөв байх" 13 дугаар зүйлийн 13.5 дахь "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Б.Ганцэцэгийн данс руу шилжүүлсэн 527,300 (Таван зуун хорин долоон мянга гурван зуун) төгрөгийн зарцуулалтын тайлан холбогдох нотлох баримтыг

6425040354

бүрдүүлэх, шийдвэрийн хэрэгжилтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2025 оны 05 дугаар сарын 26-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх[1]

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга С.Туяацэцэг, нягтлан бодогч Б.Доржнамжим нарт даалгав[2],[3].

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

АУДИТОР: Д.ЦЭДЭВЦЭВЭЭН

6417143544
ВЮА0067 9007423

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[3] Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 168/ Номгон

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Заг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын ИТХ-ын даргын 2024 оны А/10 дугаар захирамжаар ИТХ-ын төлөөлөгч нарт тойрогтоо ажиллах үйл ажиллагааны зардал тус бүр 770,000 (Долоон зуун далан долоон) төгрөгөөс нийт 14,000,000 (Арван дөрвөн сая) төгрөг данс руу нь шилжүүлсэн ба зарцуулалтын тайлан холбогдох анхан шатны баримт байхгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор баталсан "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.8-т "Төлөөлөгчийн зардлыг бэлнээр олгохгүй бөгөөд үнийн нэхэмжлэх болон бусад баримтыг үндэслэн зардлын хязгаарт багтаан холбогдох санхүүжилтийг тухайн байгууллагад шилжүүлнэ", 4.1-т "Төлөөлөгч нь үйл ажиллагааныхаа төсвийн зарцуулалтын тайлан, холбогдох санхүүгийн баримтыг зохих хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бүрдүүлж, тогтоосон журмын дагуу Хурлын ажлын албанд тухай бүр гаргаж өгнө" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан

6425040330

гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Иргэдийн төлөөлөгчдөд олгосон үйл ажиллагааны зардлын зарцуулалтын тайлан холбогдох нотлох баримтыг бүрдүүлэх, шийдвэрийн хэрэгжилтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2025 оны 05 дугаар сарын 26-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх[1]

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга С.Туяацэцэг, нягтлан бодогч Б.Доржнамжим нарт даалгав[2],[3].

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН[4]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР: Д.ЦЭДЭВЦЭВЭЭН

6417143544

---

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

[3] Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

[4] Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно